

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2016-2017 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага (байршил, өмчийн хэлбэр, ангилал)

Монгол Улсын хэмжээнд 2016-2017 оны хичээлийн жилд нийт 1,354 хүүхдийн цэцэрлэг¹ үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн 854 цэцэрлэг (27 төмөр замын харьяа хүүхдийн цэцэрлэг), хувийн 500 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 66 цэцэрлэг (төрийн 28, хувийн 38) нэмэгдсэн байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага (тоогоор)

Хичээлийн жил	Цэцэрлэгийн тоо	Өмчийн хэлбэр	
		Төрийн	Хувийн
2012-2013	945	750	195
2013-2014	1,067	764	303
2014-2015	1,177	777	394
2015-2016	1,288	826	462
2016-2017	1,354	854	500

Хувийн цэцэрлэгийн 407 буюу 81.4 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бөгөөд өмнөх оноос 47-оор нэмэгдсэн байна. Энэ хичээлийн жилд нийслэлд хувийн цэцэрлэгүүд (47) нэмэгдсэн байна.

Нийт цэцэрлэгийн 46.0 хувь нь нийслэл Улаанбаатар хотод ногдож байгаа бөгөөд өмнөх оноос 2.2 пунктээр өссөн байна.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бүлэг, хүүхдийн тоо (өмчийн хэлбэр, ангилал)

2016-2017 оны хичээлийн жилд 7,492 бүлэг хичээллэж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 459 буюу 6.1 хувиар нэмэгдсэн. (Хүснэгт 2). Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт² дунджаар 32.5 байгаа нь өмнөх жилээс 0.5-аар өссөн байна. Төрийн цэцэрлэгт бүлэг дүүргэлт 35.5 буюу өмнөх жилээс 0.7-оор, хувийн цэцэрлэгт бүлэг дүүргэлт дунджаар 21.4 буюу өмнөх жилээс 0.5-аар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг (тоогоор)

Хичээлийн жил	Бүлгийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2012-2013	5,630	4,598	1,032	5,016	3,970	1,021	614	611	3
2013-2014	6,086	5,110	976	5,177	4,206	971	909	904	5
2014-2015	6,521	5,619	902	5,294	4,403	891	1,227	1,216	11
2015-2016	7,033	6,150	883	5,655	4,783	872	1,378	1,367	11
2016-2017	7,492	6,637	855	5,908	5,055	853	1,584	1,582	2

¹ "Хүүхдийн цэцэрлэг" гэж 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг ойлгоно.

² "Бүлэг дүүргэлт" нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

Улаанбаатар хотын бүлэг дүүргэлт 34.3 бөгөөд өмнөх оноос 0.6-аар буурсан, төрийн өмчийн цэцэрлэгт 44.5, хувийн өмчийн цэцэрлэгт 20.7 буюу өмнөх оноос 0.4-өөр өссөн байна.

Нийт хүүхдийн 2.2 хувь буюу 5,292 хүүхэд Төмөр замын Хэрэг эрхлэх газрын харьяа цэцэрлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа нь өмнөх оноос 2.3 пунктээр өссөн байна.

Хүснэгт 3. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд (тоогоор)

Хичээлийн жил	Тоо	Насны бүлгээр			
		2 хүртэлх	2 нас	3-5 нас	6 нас
2012-2013	180,969	5,920	30,673	142,125	2,251
2013-2014	193,672	6,560	35,587	149,932	1,593
2014-2015	206,636	8,085	41,453	155,478	1,620
2015-2016	225,388	8,213	46,799	168,723	1,653
2016-2017	243,432	6,948	49,496	185,390	1,598

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн 219,811 буюу 90.3 хувь нь цэцэрлэгийн өдрийн, 24 цагийн үйл ажиллагаатай³ болон энгийн сургалтад хамрагдаж байгаа нь өмнөх оноос 8.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй хүүхэд (тоогоор)

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс:		Төрийн өмч	Үүнээс:		Хувийн өмч	Үүнээс:	
		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт		Цэцэрлэгт	Хувилбарт
2012-2013	180,969	150,183	30,786	167,899	137,211	30,688	13,070	12,972	98
2013-2014	193,672	167,878	25,794	174,602	148,915	25,687	19,070	18,963	107
2014-2015	206,636	182,957	23,679	181,878	158,405	23,473	24,758	24,552	206
2015-2016	225,388	201,834	23,554	196,639	173,273	23,366	28,749	28,561	188
2016-2017	243,432	219,811	23,621	209,568	185,972	23,596	33,864	33,839	25

Хувилбарт сургалт⁴-д 23,621 буюу 9.7 хувь нь хамрагдаж байгаа нь өмнөх оноос 0.8 пунктээр буурсан байна. Үүнээс 4,275 хүүхэд ээлжийн бүлэгт⁵, 16,238 хүүхэд нүүдлийн бүлэгт⁶, 3,108 хүүхэд явуулын багшийн⁷ үйлчилгээгээр дамжуулан сургуулийн өмнөх боловсролыг хүртэж байна.

Цэцэрлэгийн өдрийн ангид хамрагдаж байгаа хүүхдийг бүлгээр нь авч үзвэл: яслийн бүлэгт 2,407 буюу 1.1 хувь, бага бүлэгт 45,526 буюу 20.7 хувь, дунд бүлэгт 51,413 буюу 23.4 хувь, ахлах бүлэгт 54,529 буюу 24.8 хувь, бэлтгэл бүлэгт 55,011 буюу 25.0 хувь, холимог бүлэгт 10,925 буюу 5.0 хувь нь хамрагдаж байна.

³ “24 цагийн ажиллагаатай” гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хамтрасан шийдвэрээр ажлын 5 өдөр тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг болон бүлгийг хэлнэ.

⁴ “Хувилбарт сургалт” үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгааг хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

⁵ “Ээлжийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

⁶ “Нүүдлийн бүлгийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

⁷ “Явуулын багшийн сургалт” боловсролын стандартыг баримтлан гэр бүлд түшиглэж, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан нийт хүүхдийн 31,254 буюу 12.8 хувь нь малчдын хүүхэд байна.

Хүснэгт 5. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхэд

Хичээлийн жил	Тоо	Насны бүлгээр			
		2 хүртэлх	2 нас	3-5 нас	6 нас
2012-2013	30,561	335	3,800	25,610	816
2013-2014	29,806	304	3,881	24,892	729
2014-2015	32,734	320	4,701	26,643	1,070
2015-2016	31,977	414	5,482	25,136	945
2016-2017	31,254	387	4,814	25,233	820

Мөн 1,513 буюу 0.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 1,999 буюу 0.8 хувь нь халамж эдэлдэг, 127 буюу 0.1 хувь нь бүтэн өнчин хүүхэд байна.

Хүснэгт 6. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Үүнээс					
		Харааны	Сонсголын	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтний	Хавсарсан
2012-2013	1,300	255	59	232	110	354	290
2013-2014	1,368	246	71	242	118	389	302
2014-2015	1,437	242	82	288	119	514	192
2015-2016	1,369	218	81	252	151	390	277
2016-2017	1,513	241	102	282	170	451	267

Энэ хичээлийн жилд нийт хүүхдийн 68,867 буюу 28.3 хувь нь цэцэрлэгт шинээр элсэн орсон бөгөөд өмнөх оноос 1.2 пунктээр өссөн байна.

Багшлах боловсон хүчин

2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 25,639 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 7,302 буюу 28.5 хувийг үндсэн багш нар эзэлж байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр өссөн байна. Нийт багш, ажиллагчдын тоо өмнөх оноос 1,460 буюу 5.7 хувиар өссөн байна. Багш, ажиллагчдын 21,085 буюу 82.2 хувь нь төрийн цэцэрлэгт, 4,554 буюу 17.8 хувь нь хувийн цэцэрлэгт ажиллаж байгаа нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилчдын тоо аль аль нь нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн болон туслах багш

Хичээлийн жил	Үндсэн багш	Үүнээс:				Туслах багш
		Бүлгийн	Дуу хөгжмийн	Ээлжийн	Явуулын	
2012-2013	5,332	4,632	516	88	96	4,769
2013-2014	5,895	5,177	530	96	92	5,249
2014-2015	6,158	5,446	568	72	72	5,589
2015-2016	6,833	6,052	639	65	77	6,133
2016-2017	7,302	6,520	657	64	61	6,508

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багш өмнөх жилээс 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн боловсролын түвшин

Хичээлийн жил	Мэргэжлийн багшийн хангалт	Үүнээс:				
		Доктор	Магистр	Бакалавр	Диплом	Бусад
2012-2013	94.6	0	270	3,443	1,329	290
2013-2014	94.0	2	304	3,919	1,318	352
2014-2015	93.6	0	336	4,270	1,157	395
2015-2016	94.8	1	442	4,922	1,112	356
2016-2017	95.7	0	499	5,505	986	114

2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж байгаа үндсэн багшийн 2,192 буюу 30.0 хувь нь 29 хүртэл, 2,205 буюу 30.2 хувь нь 30-39, 2,219 буюу 30.4 хувь нь 40-49, 629 буюу 8.6 хувь нь 50-59, 57 буюу 0.8 хувь нь 60-аас дээш настай байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 95.7 хувь болсон нь өмнөх оноос 0.9 пунктээр өссөн байна.

Нийт үндсэн багшийн 2,368 буюу 32.4 хувь нь мэргэжлийн зэрэгтэй бөгөөд үүнээс 6 зөвлөх, 381 буюу 5.2 хувь нь тэргүүлэх, 1,981 буюу 27.1 хувь нь заах аргач зэрэгтэй багш нар байна. Өмнөх оноос зэрэгтэй багшийн тоо 112 буюу 4.7 хувиар өссөн дүнтэй байна.

-----000-----